



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Авто замын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /2/НА-СТА-ОНТС

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Бямбатогтох
Утас: 70350757 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	5
3.1 Ерөнхий зүйл	5
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	6
3.4 Материаллаг байдал	6
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	7
3.8 Аудитын гол асуудал	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	7
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	9

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 74
танай _____-ны № _____-т

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Н.БЯМБАЦЭЦЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Авто замын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Авто замын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,219,213,300	1,263,142,900
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,219,213,300	1,263,142,900
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,219,213,300	1,263,142,900
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,219,213,300	1,263,142,900
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,219,213,300	1,263,142,900
21	УРСГАЛ ЗАРДАЛ	351,746,389	16,506,494
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	351,746,389	16,506,494
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	351,746,389	16,506,494
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	351,746,389	16,506,494
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	867,466,911	1,246,636,406
2200	Дотоод эх үүсвэрээр	867,466,911	1,246,636,406
221001	Их засвар	867,466,911	1,246,636,406
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	-

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,219,213,300	1,263,142,900
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,219,213,300	1,263,142,900
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,219,213,300	1,263,142,900
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,219,213,300	1,263,142,900
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	351,746,389	16,506,494
21	УРСГАЛ ЗАРДАЛ	351,746,389	16,506,494
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	351,746,389	16,506,494
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	351,746,389	16,506,494
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	351,746,389	16,506,494
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	867,466,911	1,246,636,406

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	867,466,911	1,246,636,406
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	867,466,911	1,246,636,406
2200	Дотоод эх үүсвэрээр	867,466,911	1,246,636,406
221001	Их засвар	867,466,911	1,246,636,406
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(867,466,911)	(1,246,636,406)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=====	=====
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,219,213,300	867,466,911	1,263,142,900	1,246,636,406
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,219,213,300	867,466,911	1,263,142,900	1,246,636,406
2200	Дотоод эх үүсвэрээр	1,219,213,300	867,466,911	1,263,142,900	1,246,636,406
221001	Их засвар	1,219,213,300	867,466,911	1,263,142,900	1,246,636,406
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,219,213,300	867,466,911	1,263,142,900	1,263,142,900
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,219,213,300	867,466,911	1,263,142,900	1,263,142,900
132001	Орон нутгийн төсвөөс	1,219,213,300	867,466,911	1,263,142,900	1,263,142,900

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Авто замын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Бямбатогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Авто замын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06/123 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Авто замын сангийн үйл ажиллагааны чиглэл нь аймгийн замын байгууламж барих, авто замыг арчлах, завсарлахаар тодорхойлжээ.

Авто замын сангийн батлагдсан төсвөөр замын байгууламж, авто замыг арчлах, засварлах зорилготой байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Авто замын сангийн ажил гүйлгээг Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн хянадаг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Авто замын сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,263,142.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,947.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 14,210.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Авто замын сангийн 2021 оны жилийн эцсийн байдлаар батлагдсан төсөв өмнөх оноос 43,929.6 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Авто замын сан нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,397,879.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,397,879.5 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг бууруулалгүй 1,397,879.5 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсөвт 1 удаа тодотгол хийж 134,736.6 мянган төгрөгөөр бууруулж, 1,263,142.9 мянган төгрөгөөр баталжээ. Тодотголоор шилжих хөрөнгө оруулалтын зардлыг бууруулжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,263,142.9 мянган төгрөгийг санхүүжилт авч, авто замын их засварт 1,246,636.4 мянган төгрөгийг зарцуулж, 16,506.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,246,636.4 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь хөрөнгө оруулалтын санхүүжилт бүрэн олгогдоогүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Авто замын сан нь 2021 онд нийт 1,247,909.9 мянган төгрөгийн 2 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,247,909.9 мянган төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин Авто замын сангийн хөрөнгөөр авто замын тэмдэг тэмдэглэгээ, арчилгаа, хүйтэн асфальт, засвар үйлчилгээний зардалд 195,697.4 мянган төгрөгийг төлөвлөж, аймгийн ИТХ-н 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/05 дугаар тогтоолоор баталсан байна. Уг хөрөнгөөр ямар төсөл арга хэмжээ гүйцэтгэх нь тодорхой бус байна. Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-н 3.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 3.2.1-д "Төсөл, арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуурт үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12,293.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1	12,293.9	1	12,293.9			
Нийт дүн	1	12,293.9	1	12,293.9			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа болон гүйцэтгэгч байгууллагад олгосон санхүүжилтийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 195,697.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 195,697.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Авто замын сангийн хөрөнгөөр авто замын тэмдэг тэмдэглэгээ, арчилгаа, хүйтэн асфальт, засвар үйлчилгээний зардалд 195,697.4 мянган төгрөгийг Хот тохижуулах газарт шилжүүлэхээр аймгийн ИТХ-н 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/05 дугаар тогтоолоор баталсан байна. Уг хөрөнгөөр ямар төсөл арга хэмжээ гүйцэтгэх нь тодорхой бус байна. Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-н 3.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 3.2.1-д "Төсөл, арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуурт үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмблэх, үнэлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

ХОХБТХэлтэст:

Авто замын тэмдэг, тэмдэглэгээ, арчилгаа, хүйтэн асфальт, засвар үйлчилгээний зардлыг төлөвлөхдөө, ямар төсөл арга хэмжээ гүйцэтгэхийг тодорхой төлөвлөж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Авто замын сан	1	195,697.4							1	195,697.4

